

ТАНИЛЦУУЛГА

2010 оны 5 дугаар сарын 05-ны өдөр


Улаанбаатар хот

Нэг. Гомдол, мэдээллийн шийдвэрлэлт

1. Цагдаагийн байгууллага 2010 оны эхний 4 сард иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас 28249 өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авсаны 16636 буюу 58.9 хувийг гэмт хэргийн, 7291 буюу 25.8 хувийг захиргааны зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл тус тус эзэлж байна.

Хоёр. Гэмт хэргийн байдал


1. Улсын хэмжээнд энэ оны эхний 4 сард 6523 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 723 хэргээр буюу 10.0 хувиар буурчээ.




Бүртгэгдсэн бүх гэмт хэргийн 57.0 хувь нь нийслэл хотод, 41.8 хувь нь аймгуудад, 0.9 хувь нь Төмөр замын салбарт, 0.3 хувь нь бусад газарт тус тус бүртгэгдсэн байна.

Гэмт хэргийн гаралт Баян-Өлгий, Архангай, Увс, Говь-Алтай, Орхон аймагт 0.8-38.2 хувиар, нийслэлийн Баянгол, Налайх дүүрэгт 3.5-5.9 хувиар тус тус өсөв.

Гэмт хэргийн гаралт өссөн аймаг /хувиар/




Гэмт хэргийн гаралт өссөн дүүрэг /хувиар/




Харин нийслэлд 0.9, Багануур, Баянзүрх, Хан-Уул, Сонгинохайрхан Сүхбаатар, Чингэлтэй, Багахангай дүүрэгт 2.0-62.5 хувиар, Дорноговь, Дархан-Уул, Хөвсгөл, Төв, Сэлэнгэ, Завхан, Ховд, Өмнөговь, Баянхонгор, Өвөрхангай, Хэнтий, Говьсүмбэр, Сүхбаатар, Дундговь, Дорнод, Булган аймагт 1.5-40.7, Иргэний агаарын салбарт 88.9 хувиар тус тус буурав.

Гэмт хэргийн гаралт буурсан аймаг /хувиар/




Гэмт хэргийн гаралт буурсан дүүрэг, салбар /хувиар/



Бүртгэгдсэн бүх гэмт хэргийн 41.6 хувийг хөнгөн, 46.3 хувийг хүндэвтэр, 10.4 хувийг хүнд, 1.7 хувийг онц хүнд ангиллын гэмт хэрэг эзэлж байгаа ба хөнгөн ангиллын гэмт хэрэг өмнөх оны мөн үеийнхээс 4,6 хувиар өсч, хүндэвтэр ангиллын гэмт хэрэг 3.4, хүнд ангиллын гэмт хэрэг 1.0, онц хүнд ангиллын гэмт хэрэг 0.2 хувиар тус тус буурчээ.

Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал



Мал хулгайлах гэмт хэрэг 284 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 41.4 хувиар буурч, нийт хэргийн 4.4 хувийг, бусдын эд хөрөнгийг хулгайлах хэргийн 15.6 хувийг, тээврийн хэрэгсэл хулгайлах гэмт хэрэг 25 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 26.5 хувиар буурч, хулгайлах хэргийн 1.4 хувийг, халаасны хулгайн хэрэг 53 бүртгэгдэж, хулгайлах хэргийн 2.9 хувийг тус тус эзэлж байна.

Нийтийн тээвэрт үйлдэгдсэн хэрэг 53.1, гэр, орон сууцанд үйлдэгдсэн хэрэг 39.5, аж ахуйн нэгжид үйлдэгдсэн хэрэг 1.7 хувиар тус тус өсч, гаальд үйлдэгдсэн хэрэг 53.8, тооцооны төвд үйлдэгдсэн хэрэг 34.6, бэлчээрт үйлдэгдсэн хэрэг 44.4, хилийн бүсэд үйлдэгдсэн хэрэг 3.1, гудамж талбайд үйлдэгдсэн хэрэг 4.9 хувиар тус тус буурав.

2010 оны эхний 4 сард улсын хэмжээнд 190274 захиргааны зөрчил бүртгэгдсэн нь урьд оны мөн үетэй харьцуулахад 92508 буюу 32.7 хувиар буурчээ.

Мөн хугацаанд улсын хэмжээнд 37440 хүн эрүүлжүүлсэн нь урьд оны мөн үетэй харьцуулахад 10496 буюу 21.9 хувиар буурсан болно.